



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 942

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9, Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалт, "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын ерөнхий газарт 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулагдах "Албан хэрэг, архивын ажилтны мэргэжлийн сургалт" сэдэвт мэргэшүүлэх сургалтад Захиргаа, хүний нөөцийн газрын захиргааны мэргэжилтэн Г.Даарий, Аж ахуйн үйлчилгээ, дулаан, сантехникийн албаны захиргааны мэргэжилтэн Э.Бямбасүрэн нарыг тус тус хамруулсугай.

2. Сургалтын төлбөрт нийт 500,000 (таван зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу зарцуулахыг Санхүү, здийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилтнуудын ажил үүрэгт нь зохицуулалт хийхийг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг), Аж ахуйн үйлчилгээ, дулаан, сантехникийн алба (Д.Мөнхцог)-нд тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТСАЙХАН



1723 01 0340